

ДАЛД ЗҮЙРЛЭЛИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ШИНЖ

Хастуяа, Цахирмаа

Хүн төрөлхтний хэлэнд түгээмэл оршдог далд зүйрлэл гэдэг энэхүү найруулгын арга барил нь аль эрт Грекийн Аристотелийн “Найруулгын зүй” гэх номд анх эхэлж дурдагдсанаас нааш хоёр мянган жилийн түүхийн урт аяныг туулж, түүний тухай судалгаа нь тал талын хараацын олон арвин бүтээлээр гүнзгийрсээр өнөөдөрт хүрч иржээ. Тухайн үед Аристотель номдоо далд зүйрлэлийг “үгийг урнаар илтгэж байгаад бодис үзэгдлийг амьд дүрслэг болгох” найруулгын энгийн илтгэх аргаар үзэж “Төрөлжүүлэн адилтгах онол”-ыг дурдсан нь хожим хойшдын далд зүйрлэл судлалд иххэн нөлөө үзүүлсэн гэдэг боловч түүний далд зүйрлэлийн тухай үзэлт нь “Хэл ярианы чимэглэл”, “Илтгэх урлаг” хэмээх явцуухан хүрээнээс хальж чадсангүй нь харамсалтай.

Түүнээс хойш найруулга зүйн шинжилгээ нь жич түүний тухай судалгааны доройтол буурал, сэргэн мандалт, хөгжилт хувиралтын үрээр далд зүйрлэлийн судалгаа нь ч халуун хүйтэн цаг үеийг туулжээ. Хорьдугаар зуунаас эхлэн найруулга судлал жич далд зүйрлэлийн судалгаа нь дахин өрнөн хөгжиж гүнзгийрэн хүрээ цараа ч урьд гараагүй тэлжээ. Энэ хугацаанд, үе үеийн судлаачид далд зүйрлэлийг хэл шинжлэл, найруулгын зүй, сэтгэц зүй, гүн ухаан, утга зүй, хэлний хэрэглээн, заан сургалт зэрэг олон шинжилгээнтэй холбогдуулан судалсаар байж, далд зүйрлэлийн хүн төрөлхтний танин мэдэхүйлүгээгийн харьцаа холбоог таньж эхэлжээ. Аль эрт XVIII зууны сүүлчээр Английн шүлэгч Шелли далд зүйрлэл гэгчийг хүмүүний танин мэдэхүйтэй холбон “Хайрын гүн ухаан” (雷淑娟, 2014:11) гэх шүлгээ зохиомжилж, далд зүйрлэл гэгчийг хүн төрөлхтний танин мэдэхүйн харааснаас уран зохиолд оруулан ашигласан анхны хүн болжээ. Түүний дараа XX зууны наяд онд Лэкоф болон Жексоны “Манай амьдралын хэлбэр далд зүйрлэл” хэмээх ном мэндлэхийг дагалдан далд зүйрлэлийн танин мэдэхүйн судалгааны үе шат эхэлсэн байна. Лэкоф болон Жексон “Манай амьдралын хэлбэр далд зүйрлэл” гэх номдоо “Бидний хэрэг бодисын ухагдахууны тогтолцоог таних явц бол даруй далд зүйрлэл. Өөрөөр хэлбэл, бидний сэтгэхүйн явц, үйл ажиллагааны эх сурвалжийн ухагдахууны тогтолцоо бол даруй далд зүйрлэлийн шинжтэй байдаг” (Бүрэнбаатар, 2018:93) гэжээ. Лэкоф болон Жексоны энэхүү үзэлт нь одоо үеийн далд зүйрлэл судлалын шинэ онол болсноороо далд зүйрлэлийн судалгааг шинэ төвшинд ахисныг харуулж байгаа төдийгүй далд зүйрлэл гэдэг хэлний түгээмэл үзэгдэл нь үнэн мөн чанар дээрээ хүн төрөлхтний сэтгэхүй ба танин мэдэхүйн салж болшгүй арга хэлбэр ба зам явц болж байдаг гэдгийг ч эргэлзэшгүй ноттой болгожээ.

Далд зүйрлэл нь хүн төрөлхтний аль ч хэлэнд түгээмэл оршдог утгаас хүмүүс түүнийг хэлний үзэгдэл, цаашлан хэлний найруулгын үзэгдэл, бүр цаашлан найруулгын орны илтгэх арга барилын нэг болгон үзсээр хэдэн мянган жилийг туулж иржээ. Ойрхноос далд зүйрлэлийн танин мэдэхүйн чадамжийг чухалчлан судлах болсон нь хүмүүсийн далд зүйрлэлийн мөн чанарын тухай танилт гүнзгийрснийг харуулж байна. Лэкоф болон Жексон “Бидний түшиглэн оршиж бий далд зүйрлэл” гэх номдоо “Далд зүйрлэл нь бидний хэл, үйл ажиллагаа, үзэл санаанд бүр илэрч байдаг” гэсэн байдаг. Далд зүйрлэл нь зөвхөн хэлний үзэгдэл, найруулгын арга барил төдий биш, харин хэрэг бодисын ухагдахууны хүмүүсийн

тархинд бий болох, хүмүүс түүнийг хураангуйлах, зүйчлэх, боловсруулах, үг хэлний тэмдгийн хэлбэрээр илтгэх сэтгэхүй болон хэлэхүйн ажиллагааны бүхий л явц болно.

Нэг. Далд зүйрлэл бол танин мэдэхүйн суурь мөн

Хүн төрөлхтний оршин амьдарч буй орчин тойронд хэл нь хүмүүний сэтгэл санааг илтгэх багаж байдаг бол далд зүйрлэл нь уг сэтгэхүйгээс үүссэн хүмүүсийн танилтыг үг хэлэнд хэлний илтгэх явцад хүргэх бүх шатны арга зам болон явц нь мөн. Хүмүүсийн амьдрал дунд хэрэг бодисыг олж мэдэх, ухагдахуун мөн чанарыг нь таних түүнээс өөрийн амьдралд хэрэгтэйг нь сонгох, дахин түүнээ хэлний хэрэглээнд оруулахад ихэнх байдалд далд зүйрлэлийн арга барилыг ашигладаг. Даруй хоёр өөр хэрэг бодисын ухагдахууны хоорондох адил төсөөтэй шинж байдалд суурилан, нэг ухагдахууныг нь таньсан туршлагадаа тулгуурлан нөгөө ухагдахууныг ч танин мэдэж, түүнийг хэлний тэмдгээр илэрхийлэх явц болно. Энэхүү явцад, уг биеийн орон буюу үүслийн орон хийгээд шинэ биеийн орон буюу зорилгын орон гэх сэтгэцийн хоёр оронтой холбогдоно. Энэ сэтгэцийн замд төрөлжүүлэн төсөвлөх, бүхэл цогцжуулах, хураангуйлан холбон бодох, зөв оновчтой зүйчлэх, төрөл зүйлийн дотоодод нь тодорхой ялгах, бодитойгоос хийсвэр зүг улируулах, ухагдахууны эцсийн хүрээ царааг тогтоох, ухагдахууны бүтцийн хэм хэмжээг тохируулах, хэлний тэмдгээр илэрхийлэх гэх мэтийн олон удаагийн сэтгэхүйн үйл ажиллагааг дамжих болно. Эдгээр олон үйл ажиллагааны дүнд, мэдэгдэхүүнийг мэдэхүүн болгож, дахин хүртэхүйг ухахуйгаар дамжин мэдэхүй, оршихуй болгох нь даруй далд зүйрлэл бүтэх бүхий л явц мөн. Өөрөөр хэлбэл, далд зүйрлэлийн бүтцэд “Гурван бүрэлдэхүүн, хоёр бие, хоёр орон”, даруй зүйрлэхүүн, зүйрлэгдэхүүн, зүйрлэсэн шинж гэх гурван бүрэлдэхүүн, уул бие, шинэ бие, үүслийн орон, зорилгын орон гэх долоон элемент нь тэдгээр явцуудын үр дүнд л бүтэж бүрэлддэг. Иймээс, далд зүйрлэлийн үүсэл нь хүн төрөлхтөн танин мэдэхүй, узуур сэтгэхүйн нэг зүйл болох бөгөөд төрөлчлөн төсөвлөх ухамсар лугаа холбоотой, мөн зүйрлэлийн өөр хэлбэр гэж эрдэмтэд үздэг. Монголчуудын уугуул сэтгэхүйн хэлбэр нь яг далд зүйрлэл үүсэх хүн төрөлхтний сэтгэхүйн явцын нийтлэг жишээ болж болох юм. Гэхдээ монголчууд ертөнцийг танихдаа гадаад дүрс байдлаас нь эхлэн ерөнхий төлөв, бүхий л цогцоос нь очиж төрөлчлөн адилтгадаг талаараа бусад үндэстнээс огоот ялгаатай. Яг ийм өвөрмөц онцлогоос үүдэн, монгол хэлний далд зүйрлэлийн хүрээнд багтах үгийн сангийн томоохон хэсэг болсон зүйр цэцэн үг, хэвшмэл хэлц, шилжсэн утгатай үг, төлөөлөл, орлууллууд нь бусад үндэстний хэлний үгийн сан, утга зүйгээс ялгарах өвөрмөц шинжтэйгээр бүрэлдэн тогтсон байна. Түүнээс гадна, өдий төдий энгийн үгс, нэр томьёо нь бүр л тус биеэрээ далд зүйрлэл байдгийг өдөр тутмын хэрэглээн дунд хүмүүст анхаарагдахгүй болсон байдаг нь далд зүйрлэл нь амьдрал хэлэнд газар сайгүй, орчин нөхцөлгүй оршиж байдаг гэдгийн баттай гэрч болж байна. Хүмүүсийн танин мэдэхүйн үрээр ямар нэгэн бодис үзэгдлийн ухагдахууны систем бүрэлддэг, бүрэлдсэн ухагдахууны систем нь шинэ бодис үзэгдлийг таних жич түүний ухагдахууны бүрэлдлийн урьдал нь болдог. Уг ухагдахуун болон шинэ ухагдахууны улиралтын явцад далд зүйрлэл суурь хөрс нь болдог. Энэ утгаасаа далд зүйрлэл бол хүн төрөлхтөн ертөнцийг танин мэдэхийн урьдал суурь нь болдог.

Бид энэ тухай бодитой жишээгээр үзвэл:

“Бие тэргүүт дээл зах” гэх хэллэг нь “Монголын нууц товчоон”-д гардаг учир утга гүнзгий, хэлбэр бүтэц онцгой далд зүйрлэл болно гэж үзэж байна. Тус зүйрлэлийн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүнийг аван үзэхэд тодорхой биш юм шиг боловч, тухайн хэлний орчиндоо ч яв гэмээн далд зүйрлэлийн далд шинжийг өөртөө агуулсан юм. Тус зүйрлэлд, “Дээл захтай” байхаар өмсөхөд эвтэй, биед дулаахан мөртөө сүр жавхаатай харагддаг амьдралын бодит туршлагадаа суурилан хүн ах тэргүүтэй, аймаг бүлэг удирдагч дагуулагчтай байх хоёр зүйлийн төсөөтэй талыг харилцан зэрэгцүүлж, “Дээлийн зах”-аар аймаг бүлгийн ахлагчийг зүйрлэсэн байна. Бодончар Түнхэлэг горхины иргэдийг нэлээд

өдрийн харилцаа ба ажиглалтаар ахлагчгүй, “сайн муу, тэргүүн шийрийн ялгалгүй”-г танин мэдсэн туршлагын үр дүн мөн. Бодончар яг иймэрхүү далд зүйрлэлийн аргаар тэдгээр иргэдийг эзлэн авах санаагаа гурвантаа гаргаж хэлэхэд ах нь ойлгож чадсангүйн шалтгаан энэ буюу.

Монгол ардын аман зохиол, ардын дуунд байнга тохиолддог “Унасан шороо алт уусан ус рашаан” гэдэг хэллэг нь монголчуудын нутаг усаа хэр зэрэг дээдэлдгийнх нь үг хэлний шууд гэрч нь болдог. Тус хэллэгт, “Унасан шороо”-г алтаар, “Уусан ус”-ыг рашаанаар тус тус зүйрлэж далд зүйрлэлийн сонгодог жишээ болж чаджээ. Тус жишээг монголчууд хүн бүхэн мэддэг авч далд зүйрлэлийн хувьд харин анхаарч үзээгүй магад. Энд алт гэдэг эрдсийн өнгөөр нь биш харин түүний ховор нандин, хэзээ хаа ч цэвэр цул чанараа хадгалдаг, бүгд эрдэнэсийн охь дээд нь болдог эрхэм чанараар нь өөрийн өсч төрсөн нутгийнхаа өнө шимтэй хөрс шороо, өгөөмөр баян өвс бэлчээрийг зүйрлэж, рашаан усаар нутгийнхаа шим сүүтэй гол усыг зүйрлэсэн байна. Үндэстэн бүхний танин мэдэхүйн шинж адилгүй байдгийн гэрч нь, монголчууд алтны шижир өнгөөр нь хөрс шороог зүйрлэсэн биш, харин юмс үзэгдэл хэрэг бодисыг урьдаар бүхэл бүтнээр нь танин мэдэж, түүнийг төрөлчлөн төсөвлөх ухамсраар хүлээн авдаг өвөрмөц сэтгэхүйтэй шууд холбоотой. Монголчууд алт болон рашаан гэх хоёр байгалийн бодисын чанар хэрэгцээ, өгөөж үйлдлийг сайн таньснаас эх нутгийнхаа хөрс шороо, ус мөрнийхөө эрхэм чанарыг илтгэхдээ түүнийг шилжүүлэн авч хэрэглэсэн нь даруй танин мэдсэн нэг зүйлээр шинээр танин мэдэж байгаа нөгөө зүйлийг орлуулан нэрлэх далд зүйрлэлийн сэтгэхүй болон аргын уялдаа болох юм. Монгол хүний сэтгэхүйд нутаг ус нь хамгийн эрхэм нандин байдгийн аяандааны тусгал, харин зориуд үг эрж, найруулгын ямар нэгэн илтгэх арга хайсан явдал биш, харин таньсан зүйлээр таниагүй зүйлээ шууд шилжүүлэн нэрлэх далд зүйрлэл бол хүмүүсийн сэтгэхүй, сэтгэц, сэтгэлгээ, холбон бодолт, илтгэмж зэрэг олон явцыг маш хурдан өнгөрөөж бий болдог “Танин мэдэхүй, сэтгэхүй, хэлний гурвалжин” цагийн төвлөрөл мөн. Энэ бүхний суурь нь даруй далд зүйрлэл бүтээх бүхий л явц болно. Энэхүү явцад, алт болон рашаан гэх хоёр бодисын ухагдахуун урьдаар бүрэлдэн, дараа нь түүнээр түүнтэй адил төсөөтэй зүйлийг орлуулан нэрлэхэд, шийдвэрлэх үйлдэл үзүүлж байгаа нь даруй танин мэдэхүйн явц, өөрөөр хэлбэл, таньсан ухагдахуунаар танил бус зүйлийг таних явц болно, таньсны эцсийн үр дагавар нь далд зүйрлэлээр илэрч байна. Энэ утгаасаа далд зүйрлэл бол танин мэдэхүйн суурь урьдал нь, мөн эцсийн үр дүн нь болж байна. Энэ нь яг Лэкофын хэлсэнчлэн “Ухагдахууны зүйрлэл нь үүслийн байр болон зорилгын байрын ухагдахуунаас үүсэж, нэгээр нь нөгөөг нь дамаар тусган илрүүлэх явц болох юм”. Үүслийн орон гэдэг ойлгогдохуун бол танин мэдэхүйн уг суурь нь, даруй үүслийн эх сурвалж нь болдог.

Үүнийг дахин хэдэн жишээгээр нарийвчлан үзвэл:

“Танилцахаас өмнө талын хоёр гөрөөс танилцсаны дараа тагнайн хоёр судас” (Зүйр үг). Тус жишээнд, хээр талд санаагаараа давхидаг, сар жилээр бараа нь харагддаггүй, энгүй өргөн талын энэтэй тэнтэй байдаг хоёр гөрөөс шиг зайтай бөгөөд ижил бус хоёр гөрөөсөөр хоёр хүний танилцаж нүүр хагарахаас өмнөх байдлыг, танилцсаны дараах хоёр хүний харьцааг ойрхон байдаг мөртөө аль алин нь дутаж болшгүй хүний тагнайн хоёр судсаар тус тус төлөөлүүлэн зүйрлэсэн байна. Энд талын хоёр гөрөөс болон тагнайн хоёр судас бол үүслийн байрд байж, зорилгын байран дахь танилцахаас өмнө болон танилцсаны дараа хоёр илтгэвэрт тус тус танин мэдэхийн суурь нь болж өгч байна. Хэрвээ талын хоёр гөрөөс, тагнайн хоёр судас хоёр илтгэврийн угаас байсан танихуй байр байхгүй бол танилцахаас өмнө болон танилцсан дараах хоёр зорилго ч бүрэлдэж эс чадна. Далд зүйрлэлийн бүхий л явц нь танин мэдэхүйн бүхий л явцтай яг таг зохицолдож байгаагаараа далд зүйрлэл бол танин мэдэхүйн ижил алхамт сэтгэхүйн явц мөн, даруй далд зүйрлэл эхэлж бүтэхийн зэрэг хэрэг бодисын ухагдахуун анх эхлэн бүрэлдэж, аажмаар зорилгын байр тийш шилждэг байна. Энэхүү явц дунд далд зүйрлэл нь хүний тархины сэтгэхүйн бүх үйл ажиллагааг

жолоодож байдаг бөгөөд дуусан дуустал удирдаж, ухагдахуунуудын төсөөтэй талыг харьцуулах, адил талыг нь барьж хийсвэрээс бодтойжуулах, орлуулах, төлөөлөх, давуулах, шилжүүлэх, зорилгын байранд тохих, шинэ ухагдахууныг илтгэх зэрэг бүхий л үйл ажиллагааг зохион байгуулдаг. Ийм учраас, хүн төрөлхтөн баларлаг үед дэлхий ертөнцийг анх эхэлж таних үед шууд аргаар ухагдахууныг хураангуйлж, дахин түүнийг нэрлэж таньж байсан бол танилтын улам гүнзгийрэх болон өргөжихийг дагалдан улам улмаар далд зүйрлэлийн хэлбэрээр танин мэдэх нь олширсон гэх таамаг гаргахад эргэлзээгүй байна. Нэгээс нөгөөг, нэгээс хоёрыг, хоёроос дөрвийг, цөөнөөс олныг, өнгөн талаас гүнзгийг танин мэдэх явцад далд зүйрлэл нь яахын аргагүй хүн төрөлхтний танин мэдэхүйн хандлага ба багаж хэрэглүүр болсоор иржээ.

Хоёр. Далд зүйрлэл бол танин мэдэхүйн холбон бодолт мөн

Далд зүйрлэл бий болох явцад, хоёр ойр төсөөтэй хоёр зүйлийн хэрэг бодисын хооронд хүмүүс холбон бодолтын сэтгэхүйн ажиллагааг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, зүйрлэгдэхүүн болон зүйрлэхүүний хоорондох харьцааны талаар нэг систем бүхий холбон бодолтын явцыг гүйцэтгэнэ. Холбон бодолт бол далд зүйрлэл бүтээхийн зайлшгүй явц болно. Өдөр тутмын амьдрал дунд бид зарим хүн холбон бодохдоо сайн, зарим хүн муу гэдэг нь даруй ойр төсөөтэй хэрэг бодисын хоорондох харьцааны талаарх танин мэдэхүй балархай буюу танин мэдэхүй үгүй байхтай холбоотой. Хэрэг бодисын харьцааны талын мэдлэг мэдэц сайн бол холбон бодолт өргөн дэлгэр, эс тэгвэл холбон бодолт дутмаг байдаг. Холбон бодолт дутмаг байвал зүйрлэл бүтээх чадвар мөхөс, үг хэлний илтгэх боловсрол муу, үхмэл хэвшмэл, үгийн сан ядуу байдаг. Энэ утгаасаа холбон бодолт нь гагц хүмүүсийн сэтгэхүйн асуудал биш, харин танин мэдэхүйн олон цөөн, гүн гүехний асуудал болно. Иймээс нэг ухагдахуунаар нөгөө ухагдахууныг таних, түүнийг илэрхийлэх, шинэ үг хэллэг бүтээх бүхий л явцад, сэтгэхүйн талын үндсэн шалтгаан, арга хэлбэр, систем тогтолцоо, цаашлан нэг ухагдахуунаас нөгөө ухагдахуунд хүрэх сэтгэхүйн явц ямар байгааг судлах нь чухал болно. Хүний танин мэдэхүйн холбон бодолт нь далд зүйрлэл бүтээх үндсэн бүтцийг тогтоож байдаг. Хоёр юм үзэгдлийн хоорондох харьцааны тухай аль нэгэн талаас нь холбон бодож нэгийг нөгөөгөөр нь зүйрлэсэн бол тийм зүйрлэхүүнтэй далд зүйрлэл бүтээнэ. Өөрөөр хэлбэл, далд зүйрлэлийн бүтэц нь холбон бодолтын хүрээ хэвчээ, арга хэлбэрээс тогтогдоно. Монгол хэлний далд зүйрлэл бүтээх холбон бодолтын арга хэлбэр болон төрөл зүйлийг бид бодитой жишээгээр ангилан задалж үзэх болно. Хүний танин мэдэхүй нь эртний баларлаг үеэс одоо болж иртэл хэд хэдэн үе шатыг өнгөрөөсөн байдаг. “Сэтгэхүйн ухааны хувиас ажиглавал, хүн төрөлхтний сэтгэцийн хөгжлийн явцыг ихэвчлэн логикоос өмнөх сэтгэхүй ба логик сэтгэхүй гэж хоёрлон хуваана. Хүмүүс өмнөхийг нь домоглог сэтгэхүй гэж, хойнохыг нь шинжлэх ухаанч сэтгэхүй гэдэг. Домоглог сэтгэхүйн шатан дахь хүн хоёр юмны хоорондох жижиг сажиг зөрөө буюу өдий төдий адил шиг цагийг анхаардаг биш, харин бүхэл цогцоор, балархайгаар буюу бодтойгоор очиж ойлгодог юм. Шинжлэх ухаанч сэтгэхүй нь үүн лүгээ яг эсрэгээр хэрэг бодисын хоорондох нарийн ялгааг ширхэгчлэн ажиглаж тэдгээр үзэгдлийн мөн чанар, онцлог шинж, бэлгэ тэмдэг, үйлдэл хэрэгцээ, чадал чадавх зэргэмжийг цөм тоо физикээр хураангуйлан хэрэг бодисын бусдач шинж, зөв оновчтой шинжийг чухалчилдаг” (Тогтомбаяр, 2009:130). Домоглог сэтгэхүйн үед хүмүүсийн холбон бодолт нь ерөнхийдөө хэсэг цогцыг бүхэл цогцоор үзэх, төрөлчлөн төсөөлөх ухамсрын үр дүнд явагдаж байжээ. Харин сэтгэхүйн хөгжилтийн үеийн шинжлэх ухаанч сэтгэхүйн үеийн хүмүүсийн холбон бодолт нь хэрэг бодисын тус биеийнх нь хэлбэр талаас дотоод чанар, ерөнхийгөөс тусгай шинж, бүдүүлгээс нарийлаг руу харьцуулан адилтгах болсон бөгөөд хэрэг бодистой холбоотой гадаад орчин тойрны талаас ч холбон бодож, адил төсөөтэй талыг нь тагнан хайх болжээ. Холбон бодолтын дан цулгай бус будилаантай системийг илтгэж байгаа арга

барилын үүднээс дотор нь олон төрөл зүйл, хэлбэр загвар, бүтэц давхаргат хуваан үзвэл түүний үр дүнд бүтээгдэж байгаа нь далд зүйрлэл болно.

1. Бүхэл цогц хоорондын холбон бодолт. Бүхэл цогцын холбон бодолт нь домоглог сэтгэхүйн үеийн бүхэл бүтэн биеийн хоорондын холбон бодолт болох бөгөөд монголчууд энэхүү төрлийн холбон бодолтоор ертөнцийн хэрэг бодис амьтан ургамлыг танихдаа зүйрлэлийг элбэг бүтээсэн ба бүтээсээр л байна. Тэдгээр зүйрлэлийн жишээ хэлний хэрэглээнд түгээмэл харагдана. Газрын нэрст орсон зүйрлэл: Үхэр-чулуу (үхэр чулуу), Адуун-чулуу (адун чулуу), Гэр-чулуу (гэр чулуу) Зүрх-уул, Хөхөн-уул, Тулга-уул, Эмээл-уул, Нүдэн-булаг, Хорго-хан, Ширээ-уул, Авдарантай-уул, Суман-уул, Бух-уул гэх мэт. Монголчууд байгалийн бодис үзэгдлийг танихад тэрхүү бодисын аль нэг хэсэг бүлгээр нь биш, ер нь урьдаар бүхэл бүтэн талаас нь бүдүүвчлэн таних сэтгэхүйтэй байдаг гэдгийг дээрх жишээнүүд харуулна. Тухайлбал, таван хошуу малынхаа бүтэн биеэр дамжин байгалийн чулууг холбон бодох; хүн малын биеийн эрхтний бүтэн дүрс хэлбэрээр уул хайрхныг холбон бодож дүрслэн нэрлэх онцлогтой. Адууны бие харын том гэдэг бүдүүвч ойлголтоор чулууны их багыг зүйрлэсэн нь чулуу гэдэг бодис болон адуу гэдэг амьтны бүтэц чанар, анги эд буюу бүрэлдүүнээр зүйрлэсэн шинж болгосон биш, харин чулуу болон адууны бүхэл цогцын их багын адил төсөөтэй шинжийг үндэслэн холбон бодож зүйрлэл бүтээжээ. Монголчууд юмыг анхлан танихад, бүтэн цогцоос бүтэн цогц тийших холбон бодолтыг дамждаг танин мэдэхүйн онцлог мэдрэгдэж байна. Бүтэн цогцын холбон бодолт бол монголчуудын далд зүйрлэл бүтээхийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд түүний дүнд бүтсэн зүйрлэл нь бүтэц дэгтрийн хувьд өнгөвч, бүдүүвч, шууд байдаг. Энэ мэтийн жишээ монгол хэлэнд олон бий. Амьтан ургамлын нэрст орсон зүйрлэл: морин мэлхий, нохой гөрөөс, тэмээн хяруул, морин шоргоолж, үхэр хараацай, үхэр зараг, нохой хөгц, нохой шогшуур, бух шувуу, хонин арц, ямаан арц, морин шарилж, хонин шарилж, хонин зангуу гэх мэтийн жишээнд, амьтан ургамлын жижгийг нь бог малаар, томыг нь бод малаар зүйрлэн нэрлэсэн нь монголчуудын таван хошуу малыг бие бялдраар нь бог ба бод мал гэж хуваадаг танин мэдэхүйн заншилтай шууд холбоотой. Тухайлбал, аливаа зүйлийг танин мэдэж, нэрлэн хэвшүүлэхдээ таван хошуу мал, эсвэл малжих амьдралд ойрхон байдаг нохой зэрэг тэжээвэр буюу араатан амьтны бүхэл цогцоор холбож төсөөлөн, зүйрлэн сэтгэж, шилжүүлэн нэрлэдэг. Тэнүүн цагт нь тэмээгээр тусалснаас Тэвдсэн цагт нь тэвнээр тусал (зүйр сэцэн үг), Тэмээ ямаа хоёр (өвөрмөц хэлц). Тус жишээнд, тэмээгээр том зүйлийг, тэвнээр жижиг зүйлийг тус тус төлөөлүүлэн зүйрлэж, хийсвэр ойлголтыг бодитойжуулсан нь уул сургаал үгийн утга санааг тод тунгалаг болгожээ. Энэ мэтээр дараачийн жишээнд өндөр богино хоёр ухагдахууныг тэмээ ямаагаар холбон бодож, эсрэгцэлдүүлэн зүйрлэснээр тогтсон утгын хэвшмэл хэлц болж чадсан үр дүн нь бүхэл цогцоор зүйрлэн нэрлэх нь хэлийг дүрслэг, бодтой, товч авсаар, хурц тод болгох хэл шинжлэл, найруулга зүйн үүргийг гүйцэтгэхийн зэрэг танин мэдэхүйн үндэстний онцлогийг ч тусгаж байна. Энэ мэтээр монгол баатарлаг туулиас нааш орчин үеийн уран зохиолын хэлэнд бүхэл цогцын холбон бодолтын явцаар бүтсэн зүйрлэл цөөн бус байдаг нь мөн монголчуудын танин мэдэхүй анхнаасаа далд зүйрлэлээр гарцаагүй илэрдэг түүхэн явцыг тусгаж байна.

Баатарлаг тууль дахь зүйрлэл:

“Мангасын хааны төрсөн чинь
Манай орон дахь хүмүүнтэй таарахгүй юм
Шумнасын эзэн мэндэлсэн чинь
Замбативийн улстай таарахгүй шүү
Урт хоёр жигүүртэй
Жалгын чинээ амтай
Зааны чинээ соёотой

Жараар хүнийг залгивч
Зангирч торохгүй хоолойтой
Гал улаан нүдтэй
Гасан Жуугийн хамартай
Хад адил чихтэй
Арзгар хар мангас” (Дөшбалт баатар)

Энд баатрын бие бялдрын хүдэр томыг уулаар, соёоны бүдүүн уртыг заанаар тус тус давуулан зүйрлэж, хоолойн өргөнийг жаран хүний хэмжээгээр үлгэрлэн, чихний томыг хадаар зүйрлэсэн нь туульд гардаг баатар хүний дүрийг урьдаас тодорхойлон таньсан байгаль ертөнцийн бодис амьтан үзэгдэлтэй холбон бодож, тэдгээрийн бүхэл цогцыг шууд шилжүүлэн зүйрлэхүүн болгож давуулан зүйрлэснээр баатарлаг тууль дахь зохиолын баатрын сүр хүчийг амьдлаг таниулсан төдийгүй мөн баатарлаг туулийн хэлний илрүүлэх онцлогийг ч үзүүлсэн байна. Далд зүйрлэлийн арга барил туульд өргөн тусгагдсан байдаг нь Монголчуудын танин мэдэхүйн явц жич түүнээ илтгэх гол арга барил далд зүйрлэлийн хэлбэр байсныг гэрчилнэ.

“Унадаг морийг нь хэлбэл:
Өмнөөс нь харвал
Өндөр уул гэмээр
Өвчүү цээжийг нь харж
Морь гэж таньдаг
Хажуугаас нь харвал
Хад чулуу гэмээр
Хавирга гэдсийг нь харж
Морь гэж таньдаг
Хойноос нь харвал
Ухаа дов гэмээр
Хонго гуяыг нь харж
Морь гэж таньдаг
Жалгын чинээн амтай
Жаран дөрвөн соёотой
Зуун төө чихтэй
Зандан хул морьтой” (Шилэн галзуу баатар)

Тус жишээнд, баатар хүмүүсийн унадаг морины мундаг том биетэй, мундашгүй ид чадалтай байдгийг өндөр уул, хад чулуу, ухаа дов, жалга гуутай зүйрлэн дүрслэхдээ “өндөр уул-морь, хад чулуу-морь, ухаа дов-морь, жалга-ам (морины)” гэх мэтчилэн бүхэл бүтэн цогц хоорондын холбон бодолтоор танин мэдэхүйн урьдчилгаа болгосон нь илэрхий.

“Монголын нууц товчоон”-д бүхэл цогцын холбон бодолтын далд зүйрлэлийн жишээ олон бүтээгдсэн нь уг бүтээлийг гайхамшигтай, нууцлаг, сүрлэг агууц болгосон юм. “Монголын нууц товчоон”-д ийм жишээ анх Бодончарын яриагаар илэрдэг:

“Ах аа, ах аа,
Хүн ахтай
Дээл захтай сайн
Тугаарын Түнхэлэг горхины иргэн

Түрүү шийргүйхэн иргэн, бид тэднийг эзлэе” (Монголын нууц товчоон §33)

Бодончар энэ үгийг хэлэхдээ, монголчуудын хамгийн сайн мэддэг өмсгөлийн зүйл зах заамтай дээлээр зүйрлэхүүн болгож, аймаг бүлгийн түрүү ахлагчийг зүйрлэн ахдаа Түнхэлэг горхины иргэдийг эзлэх санааг ёгтоор өгүүлэн, монгол аймгийг нэгтгэх анхны дурдлагыг гаргажээ. Энэ мэт жишээ “Монголын нууц товчоон”-д цөөнгүйгээс ахин хэдийг дурдвал:

“Зээгийн нөхөр

Зээрдийн мялаа” (Монголын нууц товчоон §255)

“Босгын чинь боол болтугай

Үүдний чинь өмч болтугай” (Монголын нууц товчоон §137)

“Бөөсний төдий амиа

Булзуулав би

Харцын төдий амиа

Халхлагдав би” (Монголын нууц товчоон §103)

гэх мэт. Орчин үеийн уран зохиолд дурдаж байгаа зүйрлэлийн жишээ нэн элбэг хэрэглэгдэнэ.

“Алсын уул авар тавар

Асган цацсан ааруулын хэмхдэг шиг

Талын мөрөн тасаг бусаг

Таслан гээсэн утасны учиг мэт” (Б.Бүрэнбэх “Санаагаараа довтол доо тэрэг минь”).

Л.Одцарын “Дээлтэй бурхад” гэдэг шүлэг нь яг бүхэл цогц хоорондын холбон бодолтоор зүйрлэх аргаар бичигдсэн юм. Шүлэгт:

“Монголын дээдэс гэж сайхан хүн байсан юм

Морьтой уул, мөртэй үүл байсан юм

Модон аягатай, удан таягтай

Монгол дээлтэй бурхад байсан юм.

Монголын галыг цахисан хэт байсан юм

Монголын талыг сахисан хот байсан юм

Монголын хаяаг тэлсэн аян байсан юм

Монголын уяаг тэлсэн баян байсан юм.

Алтай хэлтэй салхи байсан юм

Адуу малтай бороо байсан юм

Аргалын галтай аянга байсан юм

Арьсан дээлтэй цас байсан юм.

Өрөөлд барьдаг цай нь сүү байсан юм

Өөртөө байх зай нь дуу байсан юм

Үг нь үжирдэггүй үнэн байсан юм

Үсэг нь тасардаггүй онон байсан юм.

Мухлаг тэргэнд нарыг хүлсэн нүүдэл байсан юм

Модон агаруунд сарыг бүлсэн буудал байсан юм

Морин нуруунд түүхийг залсан ташуур байсан юм

Монгол гэрт төрийг зассан хаан байсан юм.

Монголын нэрийг хадгаар багладаг өмөг байсан юм
Монголын сүрийг зодгоор бэхэлдэг омог байсан юм
Монголын тэнгэрийг биеэрээ тулдаг уул байсан юм
Монголын Монголыг амиараа зольдог тууль байсан юм .
Дэлхийн нүдэнд Монголын дээдэс
Дэлтэй хөх чоно байсан юм
Дээдсээ мэдэх манай нүдэнд
Дээлтэй сайхан бурхад байсан юм”.

Тус шүлэгт бүхэл цогцын холбон бодолтоор сэтгэмжлэж бүтээсэн гучин гурван далд зүйрлэл орсон бөгөөд түүнээрээ монголын дээдсийн үүх түүх, сүр хүч, баатарлаг үйл, алдар гавьяа, соёл сэтгэлгээг багцлан тусгасан нь монгол орчин үеийн яруу найргийн санаа ахуй, туурвил зүй, шүлэг зүйн хүрээнээ далд зүйрлэлийн тархац бүрхэц, үйлдэл чадамжийг монголчуудын танин мэдэхүйтэй холбон мэдрүүлжээ хэмээн үзэж болох юм. Дээрх хэдэн жишээнээс бид далд зүйрлэлийн бий болох урьдчилааны нэгэн болох сэтгэхүйн бас нэг суурь холбон бодолтын хэлбэр жич түүний биелэгдэх явц нь бүхэл цогц хоорондын төсөөт буюу орлох шинжийн илэрхүй арга зам гарцаагүй мөн гэдгийг гэрчилж байна.

2. Бэлгэ шинжийн холбон бодолт

Байгаль ертөнцийн түмэн бодис үзэгдэл өөр өөрийн шинж тэмдэгтэй. Хүн төрөлхтөн ертөнцийн амьтан ургамал, бодис үзэгдлийн бүхэл цогцыг танин мэдсэн туршлагадаа суурилан, тухайн юмс үзэгдлийн харилцан ялгарах шинж тэмдгээр нь өөр бодис үзэгдлийг таних урьдал суурь буюу хөөрөг болгодог байна. Энэхүү явцад нэг бодис үзэгдлийн ямар нэгэн бэлгэ шинж хийгээд нөгөө бодис үзэгдлийн бэлгэ шинжийн төсөөтэй буюу ойролцоо тал хоорондын холбон бодолт хийгддэг байна. Бэлгэ шинжийн холбон бодолт нь хүмүүсийн танин мэдэхүйн гүнзгий нэгэн шатанд ахисны гэрч болох бөгөөд нэг бүхэл цогц дахь хүмүүсийн танин мэдэхүй нь задлаг хэлбэрийн гүнзгийрэл тийш хөгжсөний бэлгэ тэмдэг болох юм. Танин мэдэхүйн иймэрхүү гүнзгийрэл нь мөн далд зүйрлэлийн хэлбэрээр биелэгдсэн байдаг. Монгол хэлэнд бэлгэ шинж хоорондын холбон бодолтоор үүссэн далд зүйрлэл баатарлаг тууль, уран зохиол, зүйр сэцэн үг, хэвшмэл хэлц, өдөр тутмын ярианы хэл зэрэг хэлний хэрэглээний бүхий л хүрээнд элбэг оршино.

“Улаан Лувсан хааны охин
Урангуа авхай гэдэг бол
...
Дун цагаан шүдтэй
Дуран хар нүдтэй
Хүр хорхойн хөмсөгтэй
Хөвөн зөөлөн гартай гэнэ” (Шилэн галзуу баатар)
“Нүүртээ галтай
Нүдэндээ цогтой” (Шилэн галзуу баатар)
“Шилэн галзуу баатрын
Шилж унадаг морь нь:
Молор эрдэнэ толгойтой
Монцог эрдэнэ сүүлтэй
Дун цагаан шүдтэй

Хорон завьн чихээ
Хойш урагш хайчилсан
Хорт могойн хэлээ
Улба жилэв долоосон
Чимээгүй гүйдэлтэй
Чиглэснээрээ харайдаг
Чин шулуун зүрхтэй
Чигчийн шаргал морь” (Шилэн галзуу баатар)
“Андлай шар мангас
Андгайлж үгээ хэлсэн нь:
Номхон морины чинь ногт больё
Догшин морины чинь чөдөр больё
Гадаа морины чинь уяа больё
Ганган хүний чинь зарц больё ...” (Шилэн галзуу баатар)
“Авай гэрэл хатан нь:
Өндгөн доторх уураг болсон хонгор минь
Өөхөн доторх бөөр болсон хонгор минь
Соёо нь гүйцээгүй шовшуур хар бодон минь
Зогдор нь гүйцээгүй гунан хар тайлаг минь
Ургах нарны гэрэл болсон хонгор минь
Гарах нарны гэрэл болсон хонгор минь
Гагцхан маныхаа зүрх болсон хонгор минь
Улдсан цагт тах болсон хонгор минь
Уядсан цагт багана болсон хонгор минь
Алтан жолоогоо зөв эргүүлж
Амар мэнд эргэж ирээсэй гэв”

Дээрх жишээн дэх “Дун цагаан шүд-өнгө шинжийн зүйрлэл; Дуран хар нүд-чадавх шинжийн зүйрлэл; Хүр хорхойн хөмсөг-хэлбэр шинжийн зүйрлэл; Хөвөн зөөлөн гар-чанар шинжийн зүйрлэл; Нүүртээ галтай-өнгө шинжийн зүйрлэл; Нүдэндээ цогтой-өнгө шинжийн зүйрлэл; Молор эрдэнэ толгой-өнгө чанар шинжийн зүйрлэл; Монцог эрдэнэ сүүл-хэлбэр чанар шинжийн зүйрлэл; Дун цагаан шүд-өнгө шинжийн зүйрлэл; Хорон жавын чих-хэлбэр шинжийн зүйрлэл; Хорт могойн хэл-хэлбэр шинжийн зүйрлэл; Номхон морины чинь ногт, догшин морины чинь чөдөр, гадаа морины чинь уяа-үйлдэл шинжийн зүйрлэл; Өндгөн доторх уураг-чанар шинжийн зүйрлэл; Өөхөн доторх бөөр-чухал нандин шинжийн зүйрлэл; Соёо нь гүйцэдгүй шовшуур хар бодон, зогдор нь гүйцэдгүй гунан хар тайлаг-нас жилийн шинжийн зүйрлэл; Ургах нарны гэрэл болсон, Гарах нарны гэрэл болсон-үр өгөөжийн шинжийн зүйрлэл; Гагцхан маныхаа зүрх болсон-үнэ цэнийн шинжийн зүйрлэл; Улдсан цагт тах болсон, уядсан цагт багана болсон-өмөг түшиг, үнэ цэнтэй шинжийн зүйрлэл гэх мэтээр бодис юмсын ямар нэгэн талын шинж тэмдэг хоорондын холбон бодолтын явцад бүрэлдсэн далд зүйрлэлүүд бий. Адил төрлийн далд зүйрлэл ардын аман зохиол, зүйр сэцэн үг, хэвшмэл хэлцэд орсон жишээ дурдвал:

“Идэх нь эр барс
Хийх нь хашин бух” зан араншингийн шинжийн зүйрлэл
“Муу хүний амнаас могой мэлхий

Сайн хүний амнаас шүр сувд” чанар шинжийн зүйрлэл

“Бага хэлбэл шүлэг

Их хэлбэл улиг” чанар шинжийн зүйрлэл

“Муу үг модон улаатай

Сайн үг салхин хүрдтэй” хурдцын шинжийн зүйрлэл

“Унасан шороо алт

Уусан ус рашаан” нандин чанар шинжийн зүйрлэл

“Монголын нууц товчоон”-д бэлгэ шинжийн талыг холбон бодож бүтээсэн зүйрлэл цөөн бус байгаа нь үсэг бичгээр олдсон сурвалж бичиг дэх далд зүйрлэлийн анхны жишээнүүд болох бөгөөд тухайн үеийн монголчуудын байгаль орчин, амьдрал ахуйн тухай танин мэдэхүйн хэлбэр жич түүнийгээ илэрхийлж байсан хэл ярианы хэвшил заншлын бодит тусгал гэж хэлж болох талтай. Хуагчин эхийг

“Солонго болж сонсохын тул

Үнэг болж үзэхийн тул” (Монголын нууц товчоон §103)

“Хулгана болж хуриалдсуу

Хар хэрээ болж

Гадаагуун бүхнийг хармалдсуу” (Монголын нууц товчоон §124)

Тус хоёр жишээнд Хуагчин эмгэний нүд чихийг солонго болон үнэгний сонор ба нүдний хурц сэргэг бэлгэ шинжээр нь шууд зүйрлэжээ.

Орчин үеийн уран зохиолоос жишээлбэл:

“Эрдэнэ торгоо унтаж байгаа манцуйтай хүүхдээ задалж байгаа эхийн гараар задлаад Сүхбаатар өөд гэмшилтэй бөгөөд гомдолтой нүдээр харлаа” (Ч.Лодойдамба, Тунгалаг Тамир), “Дорж... Улаан тугаа мандуулаад улсын сүрийг бадраая гэж ганхан өгүүлсээр унтахад нь Төмөр бүсийг нь тайлж орон дээр нь хэвтүүлмэгц эзгийг буцалгаж эхлэв” (Ч.Лодойдамба, Тунгалаг тамир), “Ганзаганы сумтай та нар газар нутаг дээрээ байгаа улаан намыг яаж дийлэх билээ гээд Хатанбаатар ширтэн харлаа” (Ч.Лодойдамба, Тунгалаг Тамир), “Итгэлт: Хөрөнгийг үргэлж хөдөлгөж байхгүй бол өмхийрч илжирдэг, сохор зоосыг ч бол сэгсэрч байвал төл өгдөг юм шүү гэв” (Ч.Лодойдамба, Тунгалаг Тамир), “Жа, яахав,... эр хүн уулзахаасаа өмнө уулын хоёр гөрөөс, учирсан хойноо уушгины хоёр судас шүү дээ гэв” (Бүрэнтөгс, Дэлгэр хангай).

Дээрх хэдэн жишээн дэх “Эрдэнийн гарыг манцуйтай хүүхдээ задалж байгаа эхийн гар (Үйл хөдлөлийн зөөлөн аяархан шинжийн зүйрлэл); Доржийн хурхирахыг эзгийг буцалгахаар зүйрлэсэн (Дуу чимээний шинжийн зүйрлэл); Сум зэвсэг багатайг ганзаганы сумаар хэмээн зүйрлэсэн (Хэмжээний шинж зүйрлэл); Зоос мөнгөний арвидан баяжихыг малын төлжихөөр зүйрлэсэн (Нэмэгдэх хэмжээний шинжийн зүйрлэл); Эр хүн уулзахаасаа өмнө уулын хоёр гөрөөс, учирсан хойноо уушгины хоёр судас (Ойр дотно харьцааг заасан зүйрлэл) гэх мэтийн далд зүйрлэлүүд нь хоёр юм үзэгдлийн тус бие нь биш, харин тухайн юм үзэгдлийн ямар нэгэн талын шинж тэмдэг, бэлгэ чанар хоорондын адил төсөөтэй талаар холбон бодсон сэтгэхүйн ажиллагааны үр дагавар болох юм. Хоёр амьтан бодис, үзэгдэл буюу хийсвэр ухагдахууны хоорондын чанар чансаа, хэлбэр дүрс, зан араншин, үйлдэл чадамж, үнэ цэн зэрэг бэлгэ шинжийн ойр төсөөтэй талаар холбон сэтгэмжилж, хийсвэр зүйлийг урьд нь таньсан бодитой зүйлтэй холбон бодож түүнийгээ далд зүйрлэл болгон ухагдахуунаас хэлэхүй тийш, нэгээс нөгөө тийш, хийсвэрээс бодитой тийш, бүхэл цогцоос хэсэг бүлэг, бүтэн биеэс эд анги тийш нь холбон бодолтын явцаар дамжин сэтгэхүйн нарийсаж гүнзгийрэх оюун тархины үйл ажиллагааны үр дүнд танин мэдэхүйн хүрээ цараа өргөтөж, байгаль ертөнцөд оршин амьдрах орон зай тэлж байгаагийн нэгэн арга зам бол далд зүйрлэл байгаа ухаантай.

Далд зүйрлэл бүтэхэд, зүйрлэгдэхүүн ба зүйрлэхүүний харьцаа холбоо, танин мэдэхүйн арга зам, жич туршлагын суурь зэрэг гол элементээс салж болдоггүй. Яг Лэкофын хэлсэнчлэн “Амьдралын туршлагагүйгээр хүмүүст ойлгогддог эсвэл хүмүүст мэдрэгддэг далд зүйрлэл гэж оршихгүй”. Энд хэлж байгаа амьдралын туршлага нь хүмүүсийн нэгэнт таньсан, мэдсэн, биечлэн өнгөрүүлсэн зүйл, өөрөөр хэлбэл танин мэдэхүйн бүхий л ололт мэдлэг болох юм. Хүмүүсийн сэтгэхүй, танин мэдэхүйн арга хэлбэр, хүрээ хэвцээ болон хэлний илтгэх арга маяг адил бусаас болж адил бусын бүтэцтэй далд зүйрлэл хэлэнд бий болж хүмүүсийн хэл яриаг амьд дүрслэг, уран баян болгож байгаагийн зэрэгцээ тэдгээр далд зүйрлэлийн үүссэн арга зам, бүтэц тогтолцооны дотоод харьцаа холбоогоос тухайн хэлтний танин мэдэхүй, соёл сэтгэхүйг өгсүүлэн мөрдөж болох юм. Тодруулан хэлэхэд, далд зүйрлэл нь одоо нэгэнт хэлний илтгэх арга хэлбэрээс халин даваад танихуй зүй, сэтгэл зүй, хүн зүйн өргөн хүрээнд судлагдах болсон нь манай амьдрал дунд далд зүйрлэл хаа сайгүй оршиж, хүмүүсийн байгаль ертөнцийн тухай танилт, амьдралын туршлага, мэдлэг мэдэц, харилцаа холбоо, үзэл ухамсар... хаа хэзээ ч далд зүйрлэл салж чадахгүй байгааг мэдрэхгүй байхын аргагүй билээ.

Номзүй

雷淑娟：“文学语言美学修辞”，学林出版社，2014年，第21页。

Бүрэнбат. 2018. *Монголын нууц товчооны үгсийн сангын судлал*. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

Дэлгэр. 2021. *Монголын нууц товчооны найруулга, жич түүний бэлгэдэл дүрийн судлал*.

Үндэстэний хэвлэлийн хороо.

雷淑娟：“文学语言美学修辞”，学林出版社，2014年，第217页。

Тогтомбаяр. 2009. *Монгол хэл зүйн танин мэдэхүйн чадавхын тухай судлал*. Лионингийн үндэстэний хэвлэлийн хороо.

乔治·莱考夫，马克·约翰逊：“我们赖以生存的隐喻”，浙江大学出版社，2015年，第18页